



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 37 (466)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай*
- *Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Зардлын дундаж норматив батлах тухай*
- *Нэрэмжит болгох тухай*
- *Махны тогтвортой хангамжийг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны арвдугаар сарын 7

№37 (466)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

590.	Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай	Дугаар 80	1106
591.	Байнгын хорооны гишүүнээр батлах тухай	Дугаар 81	1106

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

592.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 293	1106
593.	Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 294	1106
594.	Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 295	1107
595.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 298	1107
596.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тухай	Дугаар 299	1107
597.	Чимэддоржийн Сосорбарамд бригадын генерал цол хүртээх тухай	Дугаар 300	1107
598.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 301	1108

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

599.	Журам батлах тухай	Дугаар 166	1108
600.	Зардлын дундаж норматив батлах тухай	Дугаар 167	1112
601.	Бүтээгдэхүүн хуваах гэрээ батлах тухай	Дугаар 170	1113
602.	Малын удмын сангийн үндэсний төв, цөм сүргийн үржлийн төв байгуулах тухай	Дугаар 172	1114
603.	Авто замын засвар, ирчлалтын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын тухай	Дугаар 173	1116
604.	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай	Дугаар 175	1117
605.	Төрийн өмчийн хорооны зарим гишүүдийг чөлөөлөх, томилох тухай	Дугаар 177	1119
606.	Махны тогтвортой хангамжийг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 178	1119
607.	Мөнгөн шагнал олгох тухай	Дугаар 190	1121
608.	Нэрэмжит болгох тухай	Дугаар 193	1121
609.	Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай	Дугаар 194	1122
610.	Агентлаг байгуулах тухай	Дугаар 201	1122
611.	Ажилд түр томилох тухай	Дугаар 206	1122

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

612.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 09	1123
------	--	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 10 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 46 дугаар тойрогт 2006 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр явуулсан нөхөн сонгуулийн дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Өлзийсайханы Энхтүвшингийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг 2006 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 10 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Байнгын хорооны гишүүнээр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.1, 22.2 дахь хэсэг, өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Өлзийсайханы Энхтүвшинг Хууль зүйн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

2. Энэ тогтоолыг 2006 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь дэд хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд

Бүрэн эрхт Элчин сайд Нямсүрэнгийн Алиасүрэнг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Тогтохбаярын Батбаатарыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хабыейн Жардемханыг Баян-Өлгий аймгийн шүүхийн шүүгчийн, Бямбаюугийн Цолмонгэрэлийг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Чойнорын Менгэнцэцэгийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн

шүүгчийн, Дамдинсүрэнгийн Нацагийг Баянхонгор аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Гомбосүрэнгийн Сонинболорыг Ховд аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Ламгивийн Борыг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 295

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсон Дамдинсүрэнгийн Нацагийг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Хабыкейн Жардемханыг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн,

Ламгивийн Борыг Баянхонгор аймгийн шүүхийн шүүгчийн, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Раднаагийн Шүрхүүг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Чүлтэмийн Сүрэнжавыг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр

Дугаар 298

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь дэд хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Замбын Батжаргалыг эгүүлэн татсугай.
2. Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Рэнцэндоогийн Жигжидийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 299

Улаанбаатар хот

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 61 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Дорждамбын Зүмбэрэлхамыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилж, Бирваагийн

Мандахбилэгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний үүргээс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 300

Улаанбаатар хот

Чимэддоржийн Сосорбарамд бригадын генерал цол хүртээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Батлан хамгаалах яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын дарга

Чимэддоржийн Сосорбарамд бригадын генерал цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 301

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь дэд хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Унгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт

Элчин сайд Таукейн Султаныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Омбоосүрэнгийн Эрдэнэчимэгийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 166

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл олгох, зээлийн хүүг нөхөн төлөх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас бизнес инкубацийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх журам"-ыг 2 дугаар хавсралт, "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас аж ахуй эрхлэх сургалтад хамруулах, төсөл, хөтөлбөр боловсруулахад зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх журам"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 137 дугаар тогтоолын 3 дугаар зүйл, "Журам батлах тухай" Засгийн газрын 2002 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 43 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Л.ОДОНЧИМЭД

Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ЗЭЭЛ ОЛГОХ, ЗЭЭЛИЙН ХҮҮГ НӨХӨН ТӨЛӨХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10.1.2, 10.3-т заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан /цаашид "Сан" гэх/-гаас олгож байгаа зээл нь үйлдвэрлэл, үйлчилгээ эхлэх болон шинээр ажлын байр бий болгох, өргөтгөхөд боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. Зээлийг Засгийн газрын тусгай зориулалтын сангийн мөнгөн хөрөнгөөс олгоно.

1.4. Сангаас зээл олгох, зээлийн хүүг нөхөн төлөхөд зарцуулах хөрөнгийн хэмжээг хөдөлмөр

эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.5. Ажлын байр шинээр бий болгох, өргөтгөхөд нь зориулан Сангаас зээл олгох, зээлийн хүүг нөхөн төлөх үйл ажиллагааг банк, банк бус санхүүгийн байгууллага эрхэлнэ.

Хоёр. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх банк, банк бус санхүүгийн байгууллага

2.1. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх банк, банк бус санхүүгийн байгууллага нь дор дурдсан нөхцөлийг хангасан байна:

-Монгол банкнаас тогтоосон зохицоо харьцааны үзүүлэлтүүд, завсгал Соёл, гэх нэврийн шаардлагыг сүүлийн нэг жилийн турш хангасан

тухай хөндлөнгийн байгууллагын дүгнэлт гаргуулсан байх;

-зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг Сангийн өмнө бүрэн хариуцахаа илэрхийлсэн баталгаа гаргаж нотариатаар баталгаажуулсан байх;

-зээлийн үйл ажиллагааг орон нутагт явуулах боломжтой байх.

2.2 Сангаас зээл олгох үйл ажиллагааг эрхлэх банк, банк бус санхүүгийн байгууллагыг сонгох сонгон шалгаруулалтыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зарлан явуулж энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан банк, банк бус санхүүгийн байгууллагыг шалгаруулна.

2.3 Тендэрт шалгарсан банк, банк бус санхүүгийн байгууллагатай байгуулах гэрээний загварыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.4 Банк, банк бус санхүүгийн байгууллага нь зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг Сангийн өмнө бүрэн хариуцна.

2.5 Зээлийн хүүгийн хэмжээ нь Сангаас мөнгөн хөрөнгийг байршуулсан банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн хүүгийн доод хэмжээтэй тэнцүү байна.

Гурав. Банк, банк бус санхүүгийн байгууллагатай байгуулах гэрээ

3.1 Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтаар шалгарсан банк, банк бус санхүүгийн байгууллагатай зээлийн үйл ажиллагаа эрхлэх талаар гэрээ байгуулна.

3.2 Гэрээнд дараахь асуудлыг тусгасан байна:

3.2.1. талуудын эрх, үүрэг, хариуцах албан тушаалтан;

3.2.2. эцсийн зээлдэгчид олгох зээлийн хэмжээ, хүү, хугацаа;

3.2.3. зээлийн санд тавих хяналт;

3.2.4. зээлийн хөрөнгийг эгүүлэн татах нөхцөл;

3.2.5. хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах нөхцөл;

3.2.6. гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа;

3.2.7. гэрээг цуцлах нөхцөл.

Дөрөв. Зээл олгох үйл ажиллагаа

4.1. Зээл авахыг хүссэн хувиараа, эсхүл өрхийн аж ахуй, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр

үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хүсч байгаа ажилгүй иргэн болон малчин, албан бус хөдөлмөр эрхлэгч нь аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн албанаас сургалт, түүнчлэн мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан тухай тодорхойлолт авч банк, банк бус санхүүгийн байгууллагад хандана. Энэхүү тодорхойлолт нь зээл олгоход шаардагдах баримт бичгийн бүрдэл хэсэг болно. Банк, банк бус санхүүгийн байгууллага нь аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны тодорхойлолтугйгээр зээл олгохгүй.

4.2. Банк, банк бус санхүүгийн байгууллага нь зээл олгох эсэх асуудлыг дангаараа шийдвэрлэнэ.

4.3. Эцсийн зээлдэгчид зээлийг нэг жил хүртэл хугацаагаар олгох бөгөөд түүний дээд хэмжээ нь 10.0 /арван/ сая төгрөг хүртэл байна.

4.4. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь шинээр бий болгох, өргөтгөх ажлын байрны талаар зээлдэгчидтэй байгуулсан гэрээг үндэслэн ажлын байрны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлнэ.

Тав. Зээлийн хүүгийн нөхөн төлөлт

5.1. Аж ахуй эрхлэх болон тодорхой мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамрагдан хувиараа хөдөлмөр эрхлэх, аж ахуйн үйл ажиллагаагаа өргөтгөх хүсэлтэй ажилгүй иргэн болон малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг харгалзан материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зэргийг худалдан авахад нь зориулж нэг хүртэл жилийн хугацаатай олгосон 1.0 /нэг/ сая хүртэлх төгрөгийн зээлийн хүүг нэг удаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн олгож болно.

5.2. Нөхөн төлөх зээлийн хүүг банк, банк бус санхүүгийн байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр дамжуулан олгох бөгөөд түүний хэмжээ нь тухайн банк, банк бус санхүүгийн байгууллагаас сонгон шалгаруулалтад оролцохдоо зарласан хүүгийн доод хэмжээнээс хэтрэхгүй байна.

5.3. Ажлын байр бий болгох, зээлийг эргэн төлөх талаар Хөдөлмөр эрхлэлтийн алба болон зээл олгогч байгууллага, зээлдэгч гурвалсан гэрээ байгуулна.

5.4. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 5.3-т заасан гэрээний биелэлтийг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээлийн хүүг нөхөн олгож болно.

5.5. Тухайн жилд зээлийн хүүг нөхөн төлөхөд зарцуулах хөрөнгийн хэмжээ нь Хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих сангаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10.3-т заасан зориулалтаар олгохоор банк, банк бус санхүүгийн байгууллагад байршуулах нийт хөрөнгийн гуравны нэгээс хэтрэхгүй байна.

Зургаа. Гэрээний биелэлтэд тавих хяналт, тайлан

6.1. Ажлын байр бий болгох талаар эзэлдэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд

аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн алба хяналт тавина.

6.2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн алба нь банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн болон зээлийн хүүгийн нөхөн төлөлтийн мэдээг дараа сарын 10-ны дотор авч нэгтгэн мөн сарын 15-ны дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолын 2 дугаар хэсвэрлэлт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС БИЗНЕС ИНКУБАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Ж У Р А М

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10.1.3-т заасны дагуу бизнес инкубацийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Бизнес инкубацийн үйлчилгээ нь жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон эрхлэхийг хүссэн иргэнд үйлдвэрлэл, үйлчилгээний байр, мэдээллээр хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх чиглэлээр дэмжлэг үзүүлж аж ахуй эрхлэх таатай орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас бизнес инкубацийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зарцуулах хөрөнгийн хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.4. Бизнес инкубацийн үйлчилгээг мэргэшсэн сургагч багш бүхий зөвлөгөө өгөх төв болон бизнес инкубаторын төвүүд зохион байгуулна.

Хоёр. Бизнес инкубацийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх

2.1. Дор дурдсан бизнес инкубацийн үйлчилгээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлнэ:

2.1.1. үйлдвэрлэл, үйлчилгээ эхлэх болон өргөтгөхийг хүссэн бөгөөд бизнесийн шинэ санаа гаргасан иргэнд бизнес инкубацийн орчинд ажлын байр болон оффисийн үйлчилгээгээр тодорхой хугацаагаар хангах, үе шаттайгаар ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх;

2.1.2. бизнес инкубацийн орчинд ажиллаж байгаа иргэнд аж ахуй эрхлэх болон нарийн мэргэжлийн дэвшилтэт технологийн үр чадвар эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтад хамруулах, мэргэжлийн чиглэлийн мэдээллээр

хангах, зөвлөгөө өгөх замаар бие даан аж ахуй эрхлэх чадвар бий болгох;

2.1.3. бизнес инкубацийн орчинд ажиллаж байгаа иргэнд аж ахуй шинээр эхлэх, өргөтгөхөд нь зориулан санхүүгийн түрээсийн /лизингийн/ үйлчилгээнд хамрагдахад чиглэсэн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

2.1.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10.3-т заасан зориулалт, нөхцөлөөр олгосон зээлийн хүүг нөхөн төлөх;

2.1.5. бизнесийн орчин бүрдүүлэхтэй холбогдсон мэдээлэл түгээх, сурталчилгаа хийх, тухайн чиглэлээр хамтран ажиллагчдын талаархи мэдээллийн сүлжээг бүрдүүлэх үйлчилгээг үзүүлэх;

2.1.6. бизнес инкубацийн орчинд ажиллаж байгаа иргэнд мэдээллийн технологийн сүлжээгээр дамжуулан хамтран ажиллагч болон хэрэглэгчээ сонгох, холбоо тогтоох нөхцөлөөр хангах.

2.2. Бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдсан иргэнд тухайн жилд үзүүлэх дэмжлэгийн дээд хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн орон нутгийн онцлог, мэргэжлээр нь ялгавартайгаар тогтоож мөрдүүлнэ.

Гурав. Бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах, сонгон шалгаруулах үйл ажиллагаа

3.1. Бизнес инкубаторын төв болон зөвлөгөө өгөх төвийг сонгон шалгаруулж, тэдгээртэй хамтран ажиллах гэрээ байгуулах, бизнес инкубацийн үйлчилгээний явцад хяналт тавих, үнэлгээ өгөх ажлыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхэлнэ.

3.2. Бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэхээр шалгарсан байгууллагад хандаж бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан иргэнийг сонгох үйл ажиллагаа нь үнэлгээ

хийх, сонгох 2 үе шаттай байна. Бизнесийн шинэ санаа бүхий иргэний боловсруулсан төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулахдаа:

-сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл төсөл, хөтөлбөрт үнэлэлт өгч мэргэжлийн багт санал болгох;

-хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас томилсон тухайн чиглэлийн бизнесийн зөвлөх буюу мэргэжлийн багт дүгнэлт өгч эцсийн сонголт хийх.

3.3. Иргэний бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулахаар сонгон шалгаруулахад дараахь шалгуур үзүүлэлтийг харгалзана:

3.3.1. Бизнесийн шинэ санаа байх;

3.3.2. аж ахуй эрхлэх боломж, чадвар.

3.3.3. ажлын байр нэмэгдүүлсэн байх;

3.3.4. орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр;

3.3.5. хүрэх үр дүн, амжилт.

3.4. Бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдахаар шалгарсан иргэнтэй /бойжигч/ бизнес инкубацийн төв нь хамтран ажиллах гэрээ байгуулна. Хамтран ажиллах гэрээний загварыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.5. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь бизнес инкубацийн үйлчилгээний хүрээнд шинээр бий болсон ажлын байр, явуулсан сургалт болон мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээний талаар нэгдсэн тайлан мэдээг жил бүр гаргаж нийтэд мэдээлнэ.

Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС АЖ АХУЙ ЭРХЛЭХ СУРГАЛТАД ХАМРУУЛАХ, ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ Ж У Р А М

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10.1.1, 10.1.4–т заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Аж ахуй эрхлэх үр чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах, төсөл, хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг нь жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрх зич болон эрхлэхийг хүссэн иргэнд үйлдвэрлэл, үйлчилгээний байр, мэдээллээр хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх чиглэлээр дэмжлэг үзүүлж аж ахуй эрхлэх таатай орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. Аж ахуй эрхлэх үр чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах; төсөл, хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг мэргэшсэн сургагч багш, зөвлөгч болон Сургалт явуулах, мэдээлэл, зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан зохион байгуулна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэхүү үйлчилгээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

Хоёр. Аж ахуй эрхлэх үр чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах

2.1. Аж ахуй эрхлэх үр чадвар эзэмшүүлэх сургалтад ажилгүй иргэн, түүнчлэн малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид хамрагдана.

2.2. Аж ахуй эрхлэх үр чадвар эзэмшүүлэх сургалт нь бизнесийн анхан шатны үр чадвар, мэдлэг олгоход чиглэгдэх бөгөөд эцнээ, зайны, оройн ээлжийн байна. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь захиалга, гэрээний үндсэн дээр мэргэшсэн сургагч багш болон Сургалт явуулах, мэдээлэл, зөвлөгөө өгөх төвтэй гэрээ байгуулан энэхүү сургалтыг зохион байгуулна.

2.3. Аж ахуй эрхлэх үр чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах мэргэшсэн сургагч багш болон Сургалт явуулах, мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сонгож шалгаруулсан байгууллагын талаархи мэдээллийг нийтэд зарлана.

2.4. Аж ахуй эрхлэх үр чадвар эзэмшүүлэх сургалтад хамрагдах суралцагчийн сургалтын зардлын нэг өдрийн хэмжээ нь нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нэг өдөрт ногдох зардлаас хэтрэхгүй байх бөгөөд сургалтын зардлын зөрүүг суралцагч өөрөө хариуцна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тухайн суралцагчид зарцуулах сургалтын нийт зардал нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байна.

2.5. Аж ахуй эрхлэх үр чадвар эзэмшүүлэх сургалтын явц болон үр дүнд аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас үнэлгээ өгч, сургалтын үр дүнд бий болсон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байрны талаархи мэдээллийн

санг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээнд оруулна.

Гурав. Төсөл, хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах

3.1. Төсөл, хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ нь хувиараа хөдөлмөр эрхлэхийг хүссэн ажилгүй иргэн, түүнчлэн малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд дор дурдсан чиглэлээр аж ахуй эрхлэхтэй нь холбогдсон арга зүйн зөвлөгөө, мэдээллийг мэргэжлийн байгууллага, зөвлөгч нарын оролцоотойгоор өгөхөд чиглэгдэнэ:

- шинээр эхлэх болон эрхэлж байгаа үйл ажиллагаандаа шинжилгээ, үнэлгээ, дүгнэлт гаргуулах;

- үйл ажиллагааныхаа хөтөлбөр, зорилтыг тодорхойлох;

- бизнес төлөвлөгөө боловсруулах;
- зах зээлийн судалгаа гаргуулах;
- төсөл боловсруулах;
- зээл авахад туслалцаа авах.

3.2. Төсөл, хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага, зөвлөгч нарыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны

байгууллага сонгож, шалгарсан байгууллагын талаархи мэдээллийг нийтэд зарлана.

3.3. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас төсөл, хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө, мэдээлэл авах хүсэлт, захиалга ирүүлсэн ажилгүй иргэн, түүнчлэн малчин, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчийг шалгаруулалтаар сонгогдсон байгууллага, зөвлөгч нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамруулна.

3.4. Төсөл, хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээнд зориулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас үзүүлэх зардлын дээд хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлнэ.

3.5. Төсөл, хөтөлбөр боловсруулах арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээний үр дүн нь зээл олгож шинээр бий болгосон ажлын байрны тоогоор илэрхийлэгдэнэ. Ажлын байрны талаархи мэдээллийг аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн алба нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

Зардлын дундаж норматив батлах тухай

Боловсролын тухай хуулийн 40.2, 40.3, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 25.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг хавсралт ёсоор баталсугай.

2. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн байршил, онцлогийг харгалзан нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын хэмжээг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль бүрээр ялгавартай тогтоож байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай.

3. Ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн дотуур байранд амьдрах нэг хүүхдэд ногдох хоолны зардлын хэмжээг жилд 143.0 (нэг

зуун дөчин гурван) мянган төгрөгөөр тогтоож улсын төсвөөс санхүүжүүлж байсугай.

4. Цэцэрлэгийн нэг хүүхдийн хоолны зардлын улсын төсвөөс олгох хэмжээг жилд 39.5 (гучин есөн мянга таван зуун) мянган төгрөгөөр тогтоосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зардлын дундаж норматив, жишиг батлах тухай" Засгийн газрын 2004 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 187 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, "Зардлын норматив батлах тухай" Засгийн газрын 2005 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 177 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

Н.БАЯРТСАЙХАН

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2006 оны 167 дугаар
тогтоолын хэвсрэлт**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ БОЛОН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ТӨВИЙН АНХАН ШАТНЫ АНГИЙН НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ
ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ**

(мянган төгрөг)

№	Бүс нутаг	Аймаг, хот	Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардал	Ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардал			Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг сурагчид ногдох хувьсах зардал
				Бага анги	дунд анги	ахлах анги	
1	Баруун бүс	1. Баян-Өлгий	167.7	104.8	130.4	140	234.4
2	Баруун бүс	1. Говь-Алтай 2. Завхан 3. Увс 4. Ховд		101.6	126.2	135.3	
3	Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	158.6	98.6	120.2	133.1	225.2
4	Төвийн бүсийн говийн аймгууд	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь	158.6	98.6	120.2	133.1	225.2
5	Төвийн бүс	1. Сэлэнгэ 2. Төв 3. Дархан-Уул 4. Улаанбаатар	157.7	98.0	121.4	132.3	223.8
6	Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	159.9	99.0	122.5	133.5	229.6

Тайлбар: 1. Дээрх хувьсах зардлын хэмжээнд цалингийн сангийн зардлын эзлэх хувь цэцэрлэгт 72.0, ерөнхий боловсролын сургуульд 70.6, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд 55.0 хувь байна.

2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дүнд хоолны зардал ороогүй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

**Бүтээгдэхүүн хуваах гэрээ
батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дорнод аймгийн нутаг дэвсгэрт орших газрын тосны хайгуулын Матад-XX талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах тухай Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, "Петро Матад" ХХК-ийн хооронд 2006 оны 5 дугаар

сарын 26-ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**
**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД** **Б.ЖАРГАЛСАЙХАН**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Малын удмын сангийн үндэсний төв, цөм сүргийн үржлийн төв байгуулах тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.2.1, 4.2.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Малын удмын санг хамгаалах, малын үржлийн ажил, үйлчилгээнд биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх үүрэг бүхий Малын удмын сангийн үндэсний төвийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулан ажиллуулж, төвийн дүрмийг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Цөм сүргийн мал өсгөн үржүүлж сайн чанарын хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж бүс нутгийн хэрэгцээг хангах үүрэг бүхий Цөм сүргийн үржлийн төвийг 2 дугаар хавсралт ёсоор байгуулсугай.

3. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эзэмшилд байгаа цөм сүргийн малыг үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хамт шилжүүлэх замаар 2 дугаар хавсралтад заасан Цөм сүргийн үржлийн төвүүдийг байгуулж ажиллуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин, Төрийн өмчийн хороо /Д.СУГАР/, холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Цөм сүргийн үржлийн төвийг үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих зарчмаар ажиллуулан дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж мөрдүүлэн, захирлыг томилон ажиллуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагвад даалгасугай.

5. Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны зардлыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлж 2010 оноос аж ахуйн тооцоонд шилжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Сангийн сайд Н.Баярсайхан нарт даалгасугай.

6. Малын удмын сангийн үндэсний төв болон Цөм сүргийн үржлийн төвийн малд шаардагдах бэлчээр нутаг, уст цэгийг хуваарилан ашиглуулах арга хэмжээ авч, удирдлагын болон санхүүгийн дэмжлэг үзүүлж үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг холбогдох аймаг, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Цөм сүргийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 53 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД

Д.ТЭРБИШДАГВА

Засгийн газрын 2006 оны 172 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

1. Малын удмын сангийн үндэсний төв /цаашид "төв" гэх/ нь мал, амьтны удмын санг хамгаалах, нутгийн шилдэг омог, үүлдрийн цөм сүрэг, гадаадын арвин ашиг шимт мал, амьтны шалгарсан удмыг сайжруулагчаар ашиглах, биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг мал үржлийн ажил, үйлчилгээнд нэвтрүүлэх, малд зохиомол хээлтүүлэг хийх, мал сүргийн чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, сайжруулах талгар тэр, засгийн бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн өмчит үйлдвэрийн газар мөн.

2. Малын удмын сангийн үндэсний төв нь үйл ажиллагаандаа Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3. Малын удмын сангийн үндэсний төвийн өдөр тутмын үйл ажиллагааг төвийн захирал удирдана. Малын удмын сангийн үндэсний төвийн

орон тоо болон зардлын дээд хязгаарыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд батална.

4. Төвийн захирал нь жил бүр Хүнс, хөдөө аж ахуйн сайдтай үр дүнгийн гэрээ байгуулан түүнийг хэрэгжүүлж ажиллана. Гэрээнд нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хэмжээ, шаардагдах хөрөнгийн хэмжээ, хүрэх үр дүнгийн талаар тусгасан байна.

5. Төв нь хууль тогтоомжид заасны дагуу аж ахуйн нэгжийн гэрчилгээ, харилцах данс, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, билэгдэлтэй байна.

Гурав. Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагаа

6. Малын удмын сангийн үндэсний төв нь дараахь үйл ажиллагаа явуулна:

6.1. Мал сүргийн удмын санг хамгаалах, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах, мал үржүүлэг, нөхөн үржихүйн чиглэлээр гаргасан эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

6.2. Арвин ашиг шимт хээлтүүлэгч малын үр, хөврөл үрийг үйлдвэрлэх, үйлдвэр үйлчилгээнд нэвтрүүлэх;

6.3. Мал хээлтүүлгийн ажил, үйлчилгээнд орчин үеийн шинэ технологийг нэвтрүүлэх, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, мэдээллээр хангах;

6.4. Арвин ашиг шимтэй малын үр, хөврөл үрийг нөөцлөх, генийн сан бий болгох;

6.5. Цөм сүргийн үржлийн төв, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг үр, хөврөл үрээр хангах;

6.6. Цөм сүргийн үржлийн төв, зохиомол хээлтүүлгийн цэг, салбарыг мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах;

6.7. Үржилд ашиглах шилмэл хээлтүүлэгчийг ашиг шим, үр төлийн чанараар шалгаруулах;

6.8. Цөм сүргийн мал үржүүлэгч иргэд, малчид, аж ахуйн нэгжийн малд өндөр ашиг шимт хээлтүүлэгч малын үрээр зохиомол хээлтүүлэгч хийх ажил, үйлчилгээ явуулах, тухайн үүлдрийн шилмэл ангийн жишигт нийцсэн хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулах;

6.9. Аймаг, нийслэл, бүс нутгийн хэмжээнд гойд ашиг шимт малын үзэсгэлэн, дуудлага худалдаа зохион байгуулах;

6.10. Тоо нь цөөрч удмын сан нь алдагдах хэмжээнд хүрсэн мал, амьтны үрийг нөөцлөх, удмын санг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх;

6.11. Улсын хэмжээнд үржүүлж байгаа арвин ашиг шимт цөм сүргийн малын удам гарвал, ашиг шимийн мэдээллийн сан бий болгож,

дүн шинжилгээ хийх, үржлийн ажлын зөвлөмж, аргачлал боловсруулж хэрэгжүүлэх.

Дөрөв. Малын удмын сангийн үндэсний төвийн эрх, үүрэг

7. Малын удмын сангийн үндэсний төв нь дор дурдсан эрх эдэлнэ:

7.1. Мал үржлийн ажил, үйлчилгээг малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад төлбөртэй явуулах;

7.2. Төв нь өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах, хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, үндсэн зорилгодоо үл харшлах туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу эрхлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулах;

7.3. Мал үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах, чанар, ашиг шимийг дээшлүүлэх, нөхөн үржихүйн биотехнологийн чиглэлээр хөтөлбөр, төсөл боловсруулан хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;

7.4. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосноор гадаадын ижил төрлийн байгууллагатай холбоо тогтоох, хамтран ажиллах, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.

8. Малын удмын сангийн үндэсний төв нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

8.1. Цөм сүргийн малын чанар сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, зааврыг мөрдөн ажиллах;

8.2. Мал үржлийн ажил, үйлчилгээний ажлын явц, үр дүнгийн мэдээг үнэн зөв гаргаж хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өгөх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

Тав. Малын удмын сангийн үндэсний төвийн эд хөрөнгө

9. Малын удмын сангийн үндэсний төвийн эд хөрөнгө нь дараахь зүйлээс бүрдэнэ:

9.1. Үндсэн болон эргэлтийн хөрөнгө;

9.2. Өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого;

9.3. Гадаад дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өгсөн хандив, тусламж.

10. Малын удмын сангийн үндэсний төв нь үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлтэйгээр данснаас хасаж, борлуулж, устгана.

Засгийн газрын 2006 оны 172 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ЦӨМ СҮРГИЙН ҮРЖЛИЙН ТӨВ

№	Аймаг	Үйл ажиллагааны үндсэн чиглэл
1	Баянхонгор аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Байдраг үүлдрийн хонь сонгон үржүүлэх
2	Булган аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Хангай үүлдрийн хонь сонгон үржүүлэх Сэлэнгэ үүлдрийн үхэр сонгон үржүүлэх
3	Говь-Алтай аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Говь-Алтай үүлдрийн хонь сонгон үржүүлэх
4	Дорнод аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Махны чиглэлийн хонь болон мухар удмын үхэр сонгон үржүүлэх
5	Дундговь аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Монгол үүлдрийн хонь сонгон үржүүлэх
6	Завхан аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Сартуул үүлдрийн хонь сонгон үржүүлэх
7	Өмнөговь аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Говьгурвансайхан үүлдрийн ямаа сонгон үржүүлэх
8	Увс аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Баяд үүлдрийн хонь сонгон үржүүлэх
9	Сүхбаатар аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Үзэмчин үүлдрийн хонь сонгон үржүүлэх
10	Төв аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Хурдан удмын адуу сонгон үржүүлэх
11	Хөвсгөл аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Эрчимин хар ямаа сонгон үржүүлэх
12	Хэнтий аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Тал нутгийн цагаан үүлдрийн хонь сонгон үржүүлэх
13	Ховд аймаг, Цөм сүргийн үржлийн төв	Торгууд хонь сонгон үржүүлэх

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 173

Улаанбаатар
хот

*Авто замын засвар, арчлалтын
байгууллагуудын бүтэц, зохион
байгуулалтын тухай*

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Авто замын засвар, арчлалтын "Улаанбаатар АЗЗАН" ХК, "Булган АЗЗАН" ХК, "Хархорин АЗЗАН" ХК-иудыг 2006 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс дор дурдсаны дагуу хуваах зарчмаар тус тус өөрчлөн зохион байгуулсугай:

а/ "Улаанбаатар АЗЗАН" төрийн өмчит хувьцаат компанийг бие даасан "Улаанбаатар АЗЗА" ХК, "Дархан АЗЗА" ХК, "Сэлэнгэ АЗЗА" ХК, "Дорноговь АЗЗА" ХК, "ТТТ" ХК болгон зохион байгуулах;

б/ "Хархорин АЗЗАН" төрийн өмчит хувьцаат компанийг бие даасан "Өвөрхангай АЗЗА" ХК, "Хархорин АЗЗА" ХК, "Архангай АЗЗА" ХК болгон зохион байгуулах;

в/ "Булган АЗЗАН" төрийн өмчит хувьцаат компанийг бие даасан "Булган АЗЗА" ХК, "Орхон АЗЗА" ХК, "Хөвсгөл АЗЗА" ХК болгон зохион байгуулах.

2. Өөрчлөн байгуулагдсан дээрх төрийн өмчит хувьцаат компаниудад шилжих хөрөнгө, өр авлага, өөрийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоож компаниудын дүрмийг баталж мөрдүүлэхийг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, Төрийн өмчийн хороо /Д.СУГАР/-нд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Авто замын засвар, арчлалтын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох тухай" Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 36 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "а", "б", "в" заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Ц.ЦЭНГЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай

2006-2007 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Түлш, эрчим хүчний үйлдвэр болон зам, тээвэр, харилцаа холбоо, сургууль, цэцэрлэг, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын өвөлжилтийн бэлтгэл хангах талаар төлөвлөгөө гарган биелэлтэд нь хяналт тавьж, сургууль, цэцэрлэгийн барилгын засварыг энэ оны 8 дугаар сарын 25-ны дотор дуусгах арга хэмжээ авахыг Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин нарт үүрэг болгосугай.

2. Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн үндсэн болон туслах тоноглолын засвар, техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөсөн хугацаанд нь чанартай хийж, нүүрс, мазут нийлүүлэх, тээвэрлэх, нөөцлөх ажлыг эрчимжүүлэн энэ оны 10 дугаар сарын 1-ний дотор 20-иос доошгүй хоногийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат, Сангийн сайд Н.Баяртсайхан, Төрийн өмчийн хороо /Д.СУГАР/-нд даалгасугай.

3. Багануур, Налайхын дулааны станцын хувьчлалын асуудлыг хамтарсан ажлын хэсэг томилон судалж дүгнэлт гарган, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж энэ оны 8 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт танилцуулахыг Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат, Төрийн өмчийн хороо /Д.СУГАР/-нд даалгасугай.

4. Шарын голын уурхайн нүүрсний хангамж хүрэлцэхгүй болж Дархан-Уул, Орхон аймгийн төвийн өвөлжилтийн байдал хүндрэх нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан "Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК, "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн зууханд Багануур, Шивээ-Овоогийн уурхайн нүүрсэнд тохируулан шинэчлэлт хийх талаар холбогдох арга хэмжээ авахад хяналт тавьж ажиллахыг Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат, Төрийн өмчийн хороо /Д.СУГАР/, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт даалгасугай.

5. Цаг агаарын хүндрэлтэй үед авто зам, замын байгууламжийг авто тээврийн хөдөлгөөн саадгүй нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шуурхай ажлын хэсэг байгуулах, засвар, арчлалтын ажлыг байгууллага, иргэдэд гэрээний дагуу хариуцуулах зэрэг арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэлд үүрэг болгов.

6. Улсын нөөцөд байх тэжээлийн 50-иас доошгүй хувийг улсын төсөвт багтаан өвөр багатай, удаан хадгалагдах хүчит тэжээлээр бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд С.Отгонбаярт даалгасугай.

7. Тусгай хамгаалалттай болон улсын хилийн дагуух бус нутагт гантай байгаа зарим аймгаас тодорхой тооны мал бүхий өрхийг өвөлжүүлэх асуудлыг судалж зохих журмын дагуу шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр нарт даалгасугай.

8. Мал сүргий байгалийн болзошгүй эрсдэлээс хамгаалах болон эрсдэл багатай өвөлжүүлж, хаваржуулах зорилгоор мал бүхий иргэд бүрээр өвс, гар тэжээл бэлтгүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

9. Мал өвөлжилтийн бэлтгэл ажлын явцад хяналт тавьж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх ажлын хэсгийг орон нутагт томилж ажиллуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Монгол Улсын сайд С.Отгонбаяр, Монгол Улсын сайд У.Хүрэлсүх нарт үүрэг болгосугай.

10. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагвад дор дурдсан арга хэмжээ авахыг даалгасугай:

а/бэлтгэх өвс, гар тэжээлийн чанар, тэдгээрийн сав, баглаа боодлыг олон улсын жишигт нийцүүлэн стандартыг шинэчлэн боловсруулж батлуулан мөрдүүлэх;

б/гадаад, дотоодын зах зээлийг судалж экспортод гаргах болон дотоодод бэлтгэх махны хэмжээг нэмэгдүүлэх.

11. Дараах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

а/энэ тогтоолын хавсралтад заасан хэмжээний өвс, гар тэжээлийг бэлтгэж нөөцлөх ажлыг зохион байгуулах;

б/орон нутагт зуншлага хүндэрсэнтэй холбогдуулан өвс, хадлан бэлтгэх боломжгүй байгаа Дундговь аймгийг Төв аймгийн нутагт, Өмнөговь аймгийг Булган аймгийн нутагт, Дорноговь, Говьсүмбэр аймгийг Сэлэнгэ аймгийн нутагт, Сүхбаатар аймгийг Хэнтий аймгийн нутагт тус тус хадлангийн талбай ашиглуулж өвс, гар тэжээл бэлтгэхэд нь дэмжлэг тусалцаа үзүүлэх;

в/нутаг дэвсгэрийнхээ зуншлага, намаржилтын байдлалтай уялдуулан мал өвөлжүүлэх, отор нүүдэл хийх зураглал гарган цагийн байдал хүндэрсэн үед хэрэгжүүлэх арга хэмжээний урьдчилсан бэлтгэлийг хангах;

г/сум, багийн мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах явцад үзлэг шалгалт хийж, хэрэгжилтийг эрчимжүүлэн дүнг 11 дүгээр сарын 1-ний дотор Хүнс, хөдөө аж ахуйн яаманд ирүүлэх;

д/мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга, туулгалт, угаалгын ажлыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж, хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

е/цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ, халаалтын зуух, технологийн тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээ, туршилт тохируулгын болон түлш, эрчим хүчний үйлдвэр, зам, тээвэр, харилцаа холбоо, сургууль, цэцэрлэг, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын урсгал болон их засварын ажлыг төлөвлөсөн хугацаанд нь чанартай хийлгэж гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах;

ж/орон сууц ашиглалтын байгууллага болон Сууц өмчлөгчдийн холбоотой хамтран дундын өмчлөлийн шугам сүлжээний ашиглалтын байдалд үзлэг хийж шаардлагатай арга хэмжээ авах;

з/нийтийн тээврийн хэрэгслийн болон тэдгээрийн гараашийн засвар, дулаалгыг хугацаанд

нь чанартай хийж, сэлбэг хэрэгсэл, өвлийн улирлын шатахуун, тослох материалыг зохих хэмжээнд нь нөөцөлж иргэдэд найдвартай үйлчлэх нөхцөл бүрдүүлэх.

12. Өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилж, 21 хоног тутамд Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат, Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасгай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД**

Ж.НАРАНЦАЦРАЛТ

**ТҮЛШ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Б.ЭРДЭНЭБАТ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД**

Д.ТЭРБИШДАГВА

*Засгийн газрын 2006 оны 175 дугаар
тогтоолын хэвсрэлт*

2006 ОНД БЭЛТГЭХ ӨВС, ГАР ТЭЖЭЭЛИЙН ХЭМЖЭЭ

№	Аймаг, нийслэлийн нэр	Бэлтгэвэл зөжих нийт өвс, тэжээл /тн/	Үүнээс		
			Хадлан /тн/	Гар тэжээл /тн/	Давс, хужир /тн/
1	Архангай	72400	65200	1000	6200
2	Баян-Өлгий	48100	40300	3500	4300
3	Баянхонгор	27100	20900	2500	3700
4	Булган	76000	70000	1500	4500
5	Говь-Алтай	27800	22000	1400	4400
6	Дорноговь	10400	5000	1800	3600
7	Дорнод	62400	57000	1200	4200
8	Дундговь	16000	6500	5500	4000
9	Завхан	31900	27000	1600	3300
10	Өвөрхангай	57600	50400	3600	3600
11	Өмнөговь	11600	6000	2400	3200
12	Сүхбаатар	35000	30000	1300	3700
13	Сэлэнгэ	107600	105000	1000	1600
14	Төв	92400	85000	1200	6200
15	Увс	59600	50000	2600	7000
16	Ховд	62900	55200	2400	5300
17	Ховсгөл	69900	60700	3400	5800
18	Хэнтий	94800	85000	2800	7000
19	Дархан-Уул	51200	50000	500	700
20	Орхон	7890	7400	20	470
21	Говьсүмбэр	5600	4200	1200	200
22	Увсанбаатар	93200	80000	2000	1200
	Бүгд	1111390	982800	44420	84170



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Б.Цэрэндорж, Д.Галсандорж нарыг Төрийн өмчийн хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.
2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, Үйлдвэр, худалдааны яамны Геологи, уул уурхай, хүнд

Төрийн өмчийн хорооны зарим гишүүдийг чөлөөлөх, томилох тухай

үйлдвэрийн газрын дарга Ц.Даваадорж нарыг Төрийн өмчийн хорооны гишүүнээр тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

Н.БАЯРТСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 178

Улаанбаатар хот

Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хүнсний тухай хуулийн 5.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Мах бэлтгэн хадгалж, борлуулсан аж ахуйн нэгжид урамшуулал олгох журам"-ыг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хүн амын амьжиргааны түвшинтэй уялдуулан Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн хүн амын 2007 оны хавар, зуны хэрэгцээнд зориулан бэлтгэж нөөцлөх мах, олгогдох урамшууллын хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

4. Мах бэлтгэн хадгалж, борлуулсан аж ахуйн нэгжид олгох урамшууллыг 2007 оны төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд

Махны тогтвортой хангамжийг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Н.Баяртсайхан, холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Төв, суурин газрын зах зээлд нийлүүлэгдэж байгаа маханд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны эзлэх хувийг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Махны хангамжийг тогтвортой байлгах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 211 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД

Д.ТЭРБИШДАГВА

Засгийн газрын 2006 оны 178 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МАХ БЭЛТГЭН ХАДГАЛЖ, БОРЛУУЛСАН АЖ АХУЙН НЭГЖИД УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1. Энэхүү журмын зорилго нь Улаанбаатар хот болон томоохон хотын хүн амын махны хангамжийг тогтворжуулах зорилгоор мах бэлтгэж хадгалан, гэрээнд заасан үнийн саналаар борлуулсан аж ахуйн нэгжид Засгийн газраас урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Бэлтгэсэн махыг борлуулах үнэ

2. Бэлтгэсэн махыг борлуулах үнийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, мах

боловсруулах үйлдвэр, сүлжээ дэлгүүрийн хооронд байгуулсан гурвалсан гэрээнд тусгана.

Гурав. Мах бэлтгэх аж ахуйн нэгжийг сонгох, гэрээ байгуулах

3. Махны үйлдвэр нь хүн амын хэрэгцээнд зориулан мах бэлтгэн хадгалж борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж Засгийн газраас олгох урамшуулалд хамрагдах хүсэлтээ жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

4. Мах бэлтгэх аж ахуйн нэгжийг сонгох, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг дарга томилон ажиллуулна. Ажлын хэсэг нь сонгосон аж ахуйн нэгжид урамшуулал олгох эсэх талаархи саналаа гэрээнд заасан хугацааны сар бүрийн эцэст Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

5. Засгийн газраас олгох урамшуулалд хамрагдах аж ахуйн нэгжийг дараахь үзүүлэлтээр шалгаруулна:

5.1. мал нядлах үйл ажиллагаа эрхлэх барилга байгууламж, технологи бүхий болон ариун цэврийн шаардлага хангасан талаархи улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлттэй, үйлдвэрлэлийн явцад мал эмнэлэг, ариун цэврийн хяналтыг хэрэгжүүлж, баталгаажуулдаг тогтолцоотой байх;

5.2. "Мах, махан бүтээгдэхүүн, эрүүл ахуйн үндсэн шаардлага" MNS 5023:2001 стандартын шаардлага хангасан үйлдвэртэй, Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас олгосон итгэмжлэлийн гэрчилгээтэй байх;

5.3. нөөцлөх махны хэмжээ, бөөний болон жижиглэн худалдаалах үнийн санал;

5.4. тухайн орон нутагт байрлалтай өөрийн эзэмшлийн хөргөлттэй зоорьтой байх;

5.5. махыг мөчлөх, ангилж савлах цехтэй байх;

5.6. мах тээвэрлэх зориулалтын хөргөлттэй тээврийн хэрэгсэлтэй байх;

5.7. тухайн орон нутагт мах борлуулах өөрийн дэлгүүртэй, эсхүл хамтран ажиллах бусад дэлгүүртэй гэрээтэй байх /хамтран ажилладаг тухай тодорхойлолт, гэрээ/.

6. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь энэхүү журмын 5-д заасан шалгуурыг хянаж, сонгогдсон махны үйлдвэр болон мах борлуулах сүлжээ дэлгүүр, худалдааны байгууллагатай "Мах хадгалах, борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урамшуулал олгох" гурвалсан гэрээ байгуулж ажиллана.

7. Гэрээнд дараахь нөхцөлийг заавал тусгасан байна:

7.1. нөөцөлж хадгалах, борлуулах махны төрөл, хэмжээ;

7.2. хадгалах зоорины байршил, нөхцөл;

7.3. маханд тавигдвал зохих мал эмнэлгийн тамганы дугаар;

7.4. махыг гулуузаар буюу ангилж савласан байдлаар борлуулах хувь, хэмжээ;

7.5. борлуулах хуваарь /сар, долоо хоногоор/;

7.6. үйлдвэрээс нийлүүлэх махны үнэ, дэлгүүрийн хэрэглэгчдэд борлуулах үнэ;

7.7. урамшуулал олгох хуваарь /сараар/.

8. Гэрээг тухайн оны 12 дугаар сарын 10-наас дараа оны 7 дугаар сарын 10 хүртэл байгуулна.

Дөрөв. Бэлтгэсэн махны борлуулалт

9. Бэлтгэн хадгалсан махыг аймаг, нийслэлийн Засаг даргаас тогтоосон хуваарийн дагуу жил бүрийн 3 дугаар сарын 15-наас 7 дугаар сарын 10-ны хооронд борлуулна.

10. Махны үйлдвэр нь махыг өөрийн дэлгүүрээр борлуулах тохиолдолд борлуулах хуваарь, үнэ, гулуузаар буюу ангилж савласан байдлаар худалдах хэмжээг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай тохиролцож баталсан байна.

Тав. Хяналт тавих, зохицуулах

11. Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаа, борлуулалтын явцад энэхүү журмын 4-т заасан ажлын хэсэг тогтмол хяналт тавьж ажиллана.

12. Ажлын хэсэг нь тухайн оны 12 дугаар сарын 31-ний дотор гэрээний нөхцөлийн дагуу мах бэлтгэсэн эсэхийг газар дээр нь шалгаж, акт, холбогдох материалаар баримтжуулна.

13. Ажлын хэсэг нь махны үйлдвэртэй байгуулсан гэрээний биелэлт, дэлгүүрээр борлуулж байгаа махны үнийг сар бүр шалгаж, акт үйлдэн урамшуулал олгуулах талаархи саналаа аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

14. Махны үйлдвэр гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд урамшуулал олгохгүй.

15. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь мах борлуулах цэг, жижиглэн худалдаалах үнийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр тогтмол мэдээлж байна.

Зургаа. Санхүүжилт

16. Урамшуулалд шаардагдах хөрөнгийг аймаг, нийслэлийн тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

17. Энэхүү журмын 13-ын дагуу ирүүлсэн саналыг үндэслэн урамшуулал олгох асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар санхүүжүүлнэ.

18. Урамшууллыг гэрээнд тусган 12 дугаар сарын 10-наас эхлэн 7 дугаар сарын 10-ны өдөрөөр тасалбар болгож, сар бүр олгоно.

Засгийн газрын 2006 оны 178 дугаар
тогтоолын 2 дугаар хэсэрлэлт

2007 ОНЫ ХАВРЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛЖ НӨӨЦЛӨХ МАХНЫ ХЭМЖЭЭ, ОЛГОХ УРАМШУУЛАЛ

№	Хотуудын нэр	Нөөцлөх мах, тн (3,5 сарын буюу 115 хоногийн хэрэгцээний 35 хувь)	Олгох урамшуулал /сая төг/
1	Улаанбаатар	3300.0	834.9
2	Дархан	300.0	75.8
3	Эрдэнэт	300.0	75.8
	Дүн	3900.0	986.5

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 8 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 190

Улаанбаатар
хот

Мөнгөн шагнал олгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монахогийн Вант Улсын Монте-Карло хотноо зохиогдсон олон улсын өсвөрийн циркчдийн тэмцээнд оролцож алтан цом хүртсэн уран нугараач Ш.Азжаргал, С.Энжжин, Д.Бадамгарав нарт тус бүр 700.000 /долоон зуун мянган/ төгрөг, мөн наадмаас хүрэл медаль хүртсэн улсын циркийн жүжигчин Д.Лхагва-Очирт 2.100.000 /хоёр сая нэг зуун мянган/ төгрөг, БНХАУ-ын Учо хотноо зохиогдсон олон улсын циркийн наадамд хүрэл медаль хүртсэн уран нугараач Г.Баярмаа, О.Анударь, Б.Саранчимэг, Э.Ихбаяр нарт тус тус 3.250.000 /гурван сая хоёр

зуун тавин мянган/ төгрөгийн мөнгөн шагнал олгосугай.

2. Мөнгөн шагналд шаардагдах 17.200.000 /арван долоон сая хоёр зуун мянган/ төгрөгийг Соёл, урлагийн сангийн 2006 оны батлагдсан төсвөөс гаргахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 8 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар
хот

Нэрэмжит болгох тухай

Холбогдох байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Увс аймгийн Улаангом сумын 10 жилийн 1 дүгээр дунд сургуулийг Монгол Улсын төр, нийгмийн зүтгэлтэн, Монгол Улсын баатар, маршал Юмжаагийн Цэдэнбалыг;

2. Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын 8 жилийн дунд сургуулийг Монгол Улсын баатар Ванчинжавын Шаравыг;

3. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 10 жилийн 1 дүгээр дунд сургуулийг Монгол Улсын баатар Мазимын Икейг;

4. Хөвсгөл аймгийн Рашаант сумын 10 жилийн дунд сургуулийг хэл судлалын эрдэмтэн, мэргэн гүн Мөнх-Очирын Гомбажавыг;

5. Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 8 жилийн дунд сургуулийг Төрийн хошой шагналт, зохиолч Дашзэвэгийн Сэнгээгийг;

6. Ховд аймгийн Чандмань сумын 10 жилийн дунд сургуулийг Монгол Улсын гавьяат жүжигчин Довчингийн Сүндүйг;

7. Хөвсгөл аймгийн Галт сумын соёлын төвийг Монгол Улсын гавьяат жүжигчин Дагийрачаагийн Банзрагчийг;

8. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврах тусгай ангийг хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Сандивын Равдангийг;

9. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 жилийн 2 дугаар дунд сургуулийг Монгол Улсын гавьяат багш Даржаагийн Батсуурийг;

10. Сэлэнгэ аймгийн Мандал сумчн 10 жилийн 3 дугаар дунд сургуулийг Монгол Улсын хөдөлмөрийн баатар Очирын Дорлигсүрэнгийг;

11. Говь-Алтай аймгийн Бигэр сумын хүүхдийн цэцэрлэгийг Монгол Улсын хөдөлмөрийн баатар Дүгэрийн Санжаагийн нэрэмжит тус тус болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Ө.ЭНХТҮВШИН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 8 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай

"Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 66 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийг 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

2. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд нэг, хоёрдугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны зардлыг өдөрт 300 төгрөг байхаар тогтоосугай.

3. "Үдийн цай" хөтөлбөрийг 2006 онд хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны төсвийн багцын санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулах

замаар санхүүжүүлэхийг Сангийн сайд Н.Баяртсайханд даалгасугай.

4. "Үдийн цай" хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлэх ажлыг чанартай зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд, үдийн цайнд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, орчны ариун цэврийн талаар тогтмол хяналт тавих ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд У.Хүрэлсүхэд тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

Н.БАЯРТСАЙХАН

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 8 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Агентлаг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, 6.3, "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч

агентлаг-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрыг байгуулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 8 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

Ажилд түр томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12, Барилга, хот байгуулалтын сайдын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дагвадоржийн Долгормааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эд хөрөнгийн

эрхийн улсын бүртгэлийн газрын даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

 Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим
14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, гишүүн П.Очирбат, Ж.Амарсанаа, Ч.Дашням, Д.Наранчимэг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Баяр, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн А.Бахей, Ц.Жаргал нар оролцов.

Нэг.Иргэн Б.Баяр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад тусгасан хязгаарлалт нь хуулийн этгээд болох аж ахуйн нэгж болон аж ахуйн нэгж байгуулан үйл ажиллагаа явуулах Монгол улсын иргэн хуулийн хүрээнд, хуулиар хориглоогүй үйл ажиллагаа эрхлэн шударгаар чөлөөтэй өрсөлдөн, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийг хязгаарлан хориглож буйгаараа Үндсэн хуулийн дараах заалтуудыг зөрчиж байна.

- Нэгдүгээр зүйлийн 2-т заасан "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн";
- Тавдугаар зүйлийн 1, 2 ба 4-т заасан "Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна"; "Төр нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална"; "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх

хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна;

- Аравдугаар зүйлийн 2-т заасан "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ";
- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 ба 2-т заасан "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", "Хүнийг ...хөрөнгө чинээ, ...ялгаварлан гадуурхаж үл болно";
- Арван зургадугаар зүйлийн 3/ ба 4/-т заасан "хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй", "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй";
- Далдугаар зүйлийн 1-д заасан "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2 Дээрх заалт нь тус хуулийн бусад заалт болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай хууль, Шударга бус өрсөлдөөний тухай хуулийн заалтуудтай зөрчилдөж, улмаар уг заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн төв болон орон нутгийн байгууллагууд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь Үндсэн хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг зөрчихөд хүргэж байгаагаараа ноцтой юм. Жишээлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15.3.4-д "Төндөрт оролцогчийн сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төсөөтэй бараа, ажил үйлчилгээний жилийн борлуулалтын талаархи мэдээлэл" мөн 16.1.2,

16.1.3-д "сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төсөвтэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт"-ыг үндэслэн тендэрт оролцогчийг үнэлнэ гэж заасан.

Үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэн явуулж, бараа үйлчилгээний нь чанар, нэр хүнд зах зээл дээр тодорхой хүндлэл хүлээж, байр сууриа олсон шударга компани, аж ахуйн нэгжийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт нь үндэслэлгүйгээр зах зээл дээрх томоохон хэрэглэгч болох төрийн худалдан авах үйл ажиллагаанд орохыг хязгаарлаж хориглоход цаана нь зөвхөн шинээр байгуулагдсан, жижиг аж ахуйн нэгжүүд үлдэж байгаа юм. Эдгээр шинэ аж ахуйн нэгжүүд нь тус хуулийн 15.3.4, 16.1.2 болон 16.1.3 дугаар заалтуудын шаардлагыг хангаж чадахгүй нь тодорхой.

3. Хуулийн энэхүү заалт хэрэгжсэнээр улсын эдийн засагт тэргүүлэх чиглэлийн болон хүн амд нэн шаардлагатай бараа, үйлчилгээний чанарыг доройтуулж, улмаар түүнийг ашиглан хүн амд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, утга учрыг алдагдуулах байдалд хүрч, эцсийн дүнд улсын төсвийг үр ашиггүй зарцуулахад хүргэж байна. Нөгөөтэйгүүр аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэл, борлуулалтыг бууруулах, өрсөлдөх чадварыг бууруулан улмаар тус улсын эдийн засаг, хүн амд нэн хэрэгтэй байгаа ажлын байрыг үгүйсгэх сөрөг үр дагаврууд гарч болзошгүй болоод байна.

Жишээн дээр авч үзье: Монгол Улсын эрүүл мэндийн салбарын гол байгууллагууд төрийн өмчлөлд байгаа ба энэ салбарт нэн чухал шаардлагатай эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, био бэлдмэл, вакциныг маш өндөр бөгөөд нарийн шаардлага, шалгуурыг хангаж байж олж авсан тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагууд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нийлүүлдэг. Тус салбарын харьяа Улаанбаатарт 15 орчим, орон нутагт 25 орчим эмнэлгийн байгууллагууд тус бүрдээ тендер зарлаж нийлүүлэгчээ шалгаруулдаг ба санхүүгийн чадавхи, боловсон хүчин, ажлын байрны шаардлага, өмнө нь төсөл хэрэгжүүлж байсан туршлага гэх мэт шаардлага, шалгуурыг давж гарахын тулд өмнө нь энэ салбарт ажиллаж байсан жижиг аж ахуйн нэгжүүд нэгдэн, хүч хавсрах процесс явагдсаны дүнд одоо 4-5 томоохон аж ахуйн нэгж, байгууллага 25 шахам жижиг, дунд аж ахуйн нэгжүүдтэй гол төлөв өрсөлддөг байна. Эдгээр нь чанар сайтай бүтээгдэхүүн нийлүүлэхийн хамт үнээр өрсөлдөж, улсын төсвөөр худалдан авч буй бүтээгдэхүүний үнийг зохих хэмжээнд

бууруулан төсөвт хэмнэлт гаргах бололцоо олгодог. Гэвч дээрхи хууль батлагдан гарснаар эмнэлгийн бүтээгдэхүүн нийлүүлэгчээр 30 шинэ компани зөвхөн 2006 онд шинээр бүртгүүлсэн байна.

Аж ахуйн үйл ажиллагааны практикаас харахад нэг компани жилдээ 20-30 тендэрт оролцож улмаар наад зах нь 6-10 тендэрт ялж байж үйл ажиллагааны зардлаа нөхөн, ажилтан ажилчдаа цалинжуулж, цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах хэмжээний ашиг орлоготой ажилладаг байна. Гэтэл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын улмаас,

а/ дараалан 6 ба түүнээс дээш тендэрт оролцож, амжилт олохгүй байх нь нийтлэг үзэгдэл тул олон аж ахуйн нэгж тухайн жилдээ бизнес явуулах боломжгүй болох,

б/ төрийн болон орон нутгийн хөрөнгөөр нэг удаа худалдан авч буй хэмжээ нь бага байдаг тул 3 удаа тендэрт ялсан ч компани үйл ажиллагаагаа тогтвортой хэмжээнд явуулах тодорхой орлого ашиг олж чадахгүй,

в/ шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж компани хуулиар нэмж тавьсан шаардлагыг хангахгүй тул тендэрт оролцох боломжгүй болж байна.

Иймд нөхцөл байдалд шинээр компани байгуулан шалгуур хангаагүй байж тендэрт оролцох, хуучин компаниуд дээрх хязгаарлалтыг үл харгалзан тендэрт оролцооор байх, эцэст нь тендерийг удирдан зохион байгуулж буй төрийн байгууллагууд хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх бололцоогүй, бололцоотой байсан ч хэрэгсэхгүй өнгөрөөх улмаар энэ нь авилгал, хээл хахуульд хүргэх нөхцөл бүрэлдүүлж байна.

Эрүүл мэндийн салбар дээр авсан энэхүү жишээнд дурдсан нөхцөл байдал нь мөн эрчим хүчний, боловсрол шинжлэх ухааны, уул уурхайн зэрэг төрийн өмч давамгайлсан салбарууд дээр мөн ижил төстэй байгааг дурдах нь зүйтэй.

4. Монгол Улсын том жижиг аж ахуйн нэгж байгууллагууд ийнхүү зах зээлээс шахагдсан тохиолдолд зөвхөн гадаадын нийлүүлэгчид дээрх хуулиар заасан шаардлага, шалгуурыг хангах болж байгаа бөгөөд хэдийгээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциор/тухайлбал Дэлхийн худалдааны байгууллагын олон талт гэрээ, хэлэлцээрүүдээр/ Монгол Улс нь зах зээлээ нээлттэй байлгах үүрэг хүлээсэн ч уг зах зээл дээр шударгаар өрсөлдөх нөхцлийг мөн хангах үүрэгтэй. Дээрх хуулийн заалтууд нь харин эсрэгээр, төрөөс шударга өрсөлдөөнийг саатуулсан алхам болжээ.

Гадаадын аж ахуйн нэгж байгууллагууд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд орох эрх нь нээлттэй боловч харин бусадтай шударгаар буюу бараа үйлчилгээнийхээ чанар, үнээр өрсөлдөх ёстой болохоос Үндсэн хуульд заасан "хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх" зарчмыг зөрчсөн заалт бүхий хуулиар Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс илт давамгай эрх эдлэх ёсгүй юм. Иймд Үндсэн хуулийн заалтыг зөрчиж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг энэхүү нэхэмжлэлээр Үндсэн хуулийн маргаан үүсгэн хянан шийдвэрлэж өгөхийг хүсье" гэжээ.

Хоёр. Улсын Их Хурлын даргын 2006 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 129 дүгээр захиргаажаар томилогдсон Улсын Их Хурлын итхэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Дамиран тайлбартаа:

Иргэн Б.Баяр өргөдөлдөө: "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад тусгасан хязгаарлалт нь хуулийн этгээд болох аж ахуйн нэгж болон аж ахуйн нэгж байгуулан үйл ажиллагаа явуулах Монгол Улсын иргэн хуулийн хүрээнд, хуулиар хориглоогүй үйл ажиллагаа эрхлэн шударгаар чөлөөтэй өрсөлдөн, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийг хязгаарлан хориглож буйгаарал Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 1, 2, 4, Аравдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 3/, 4/, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчиж байна гэжээ."

Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1/ хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах; 2/ төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох; 7/ төрийн санхүү, эзл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, ... улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах асуудлыг Улсын Их Хурал өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэхээр заасан.

Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 3.1-д "Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн төсвийн жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцлийг Монгол Улсын нэгдсэн төсөв гэнэ" гэж заасан байдаг. Мөн Улсын төсвийг батлах асуудал Монгол Улсын Их Хурлын, бүрдүүлж зарцуулах асуудал Засгийн газрын бүрэн эрхэд тус тус хамаардаг. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа нь санхүүгийн зах зээлийн харилцаа бөгөөд энэ

харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулж байгаа билээ. Төр эдийн засаг, санхүүгийн зах зээлийн харилцааг Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар "Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн" зохицуулдаг билээ.

1. Ардчилсан ёс гэдэг бол аль нэг буюу хэсэг бүлэг этгээдийн бус ард түмний олонхийн санал зоригийг хэрэгжүүлэхэд оршдог бол шударга ёс нь төр, засгийн байгууллага, түүний албан хаагчдын үйл ажиллагаанд танил тал харах, хээл хахуульд автах, эрх мэдлээ урвуулан ашиглах ажиллагааг хязгаарлахад, тэгш байдал, эрх чөлөөний зарчим нь шударга ёсны зарчмаас эх үүсвэртэй бөгөөд төрөөс харьяат этгээдэд /хувь хүн, хуулийн этгээд/ үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх, хууль шүүхийн өмнө адилхан эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг хангахад оршдог билээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь хэсэг нь "хязгаарлалт" гэхээсээ "зах зээлд шударга өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн" заалт гэвэл илүү тохиромжтой гэж үзэж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах явцад урьд өмнө мөрдөж байсан журам, баримталж байсан бодлогыг харгалзан нэгдүгээрт, аль нэг этгээд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх ажиллагаанд дангаар ноёрхох, улмаар бараа, ажил үйлчилгээг хугацаанд нь худалдан авахад саад учруулахгүй байх, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагааг хязгаарлаж, өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгжүүдийг шударгаар өрсөлдүүлж илүү чадавхитай, хугацаанд нь биелүүлэх боломжтойг нь сонгох авах нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримталсан болно.

Улсын Их Хурал эрх барих дээд байгууллагын хувьд үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах бүрэн эрхийнхээ хүрээнд шударга ёсыг тогтоох, тэгш байдлыг хангах үүднээс ижил боломжийг олгох зорилгоор зарим давуу эрх бүхий аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хязгаарлах, өөрөөр хэлбэл, давамгай байдлаа шударга өрсөлдөөнд харшаар ашиглахаас хамгаалж, бусад этгээдэд боломж олгох нөхцөлийг бүрдүүлсэн учраас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

2. Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1, 2, 4 дэх заалтыг зөрчөөгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь заалт / болон хууль бүхэлдээ/ нь тендер шалгаруулалтад оролцогчийн өмчийн хэлбэрийн талаар тухайлан заагаагүй өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгжид хамаарах учир эдгээр заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна. Нөгөө талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд "Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байна" гэж заасан байдаг. Иймээс төрийн өмчийг өмчлөгчийн хувьд Улсын Их Хурал төсвийн хөрөнгийг захиран зарцуулах хүрээнд тогтоосон энэ хязгаарлалт нь Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн "Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй" гэсэн заалтын агуулгад 14.2 дахь заалт бүрэн нийцэж байгаа гэж үзэж байна. Монгол Улсын бүх иргэн, хуулийн этгээд өөрсдийн орлогоос төлсөн татварын мөнгөнөөс бүрдэж бий болдог улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа гүйцэтгэгчийг оновчтой сонгож, бараа, ажил, үйлчилгээг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, ингэснээр төрийн байгууллагууд, төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг хугацаанд нь, чанартай үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн зах зээлийн харилцаанд оролцож, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа өмчийн бүх төрлийн этгээд зах зээлд шударгаар өрсөлдөх ижил нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримталсан бөгөөд хэсэг бүлэг аж ахуйн нэгжид санхүүгийн зах зээлд давамгайлан оролцох боломж олгох буюу төсвийн хөрөнгийг цөөн хэсэг аж ахуйн нэгж давуу эрхийн үндсэн дээр ашиглах боломжийг хуулиар олгох нь буруу бөгөөд өмнө мөрдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг дагаж мөрдөх явцад гарч байсан зарим сөрөг практикийг харгалзан хуульд 14.2 дахь заалтыг тусгасан билээ.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь заалт Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн гэсэн нь үндэслэлгүй гэж үзэж байна. Учир нь энэ тухайд болон бусад бүх заалтын тухайд ерөнхийдөө зөрчсөн гэсэн үндэслэл нь тодорхой бус байна. Одоогоор Монгол Улс тендерт оролцогчийн тухайд

ямар нэг хязгаарлалт тавихгүй байх талаар олон улсын аль нэг гэрээгээр үүрэг хүлээгээгүй байна.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 ба 2, Арван зургадугаар зүйлийн 3/, 4/ дэх заалтуудыг зөрчсөн гэсний тухайд,

Үндсэн хуулийн эдгээр заалт нь "хувь хүн, иргэн" гэсэн субъектэд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, хүний салшгүй эрхийн асуудал юм. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь заалт нь өвөхөн хуулийн этгээдэд хамаарч байгаа бөгөөд Иргэний хуулийн 26.9-д "Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг гагцхүү хуульд заасан үндэслэл, журмаар хязгаарлана" гэж заасан нь хууль тогтоогчид хязгаарлалт тогтоох эрхийг олгосон бас нэг үндэслэл нь мөн.

5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь заалт Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн гэжээ.

Хууль болон төрийн байгууллагын аливаа шийдвэр нь бүх сонирхогч этгээдийн ашиг сонирхолд нэгэн зэрэг нийцэх боломжгүй, нөгөөтэйгүүр хууль бүх этгээдийн "эрхийг хязгаарлахгүй" байх боломж нь ч мөн хязгаарлагдмал бөгөөд тодорхой тохиолдолд төр, нийгмийн ашиг тусын тулд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах болон бусад тодорхой зорилгоор хэсэг бүлэг этгээдийн эрхийг хязгаарладаг. Аливаа эрх нь бусдын эрхээр хязгаарлагдаж байдаг. Үүнийг хууль тогтоогч тодорхой хууль батлах замаар тэнцвэржүүлж, хамгаалдаг билээ. Мөн хууль тогтоох байгууллага төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай гэж үзвэл хуулиар иргэн, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлах явдал ч байдаг. Энд мөрдөж байгаа хуулийн зарим заалтыг дурдъя:

- Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх заалтад Монгол Улсын иргэн "амьд явах эрхтэй" гэж тунхагласан. Үүний зэрэгцээгээр "Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэн учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ онэгдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусууныхыг хатуу хориглох" гэж заасан бөгөөд Эрүүгийн хуулийн 53.1 дэх хэсэгт "Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд

энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болно” гэсэн заалт нь “Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчиж байна” гэж болох мэт боловч хууль тогтоогч бүрэн эрхийнхээ хүрээнд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар тодорхой этгээдийн эрхийг хязгаарласан байна.

-Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь заалтад “18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэж заасан байдаг. Гэтэл Авилгалын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд : Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан албан тушаалтанд: Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт болон ажиллаж байгаа төрийн байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчихыг хориглосон байна. Энэ нь мөн л Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн гэж хэлж болох боловч хууль тогтоогч төрийн тодорхой бодлогыг хэрэгжүүлэх-авилгалаас сэргийлэхийн тулд энэхүү хязгаарлалтыг хийсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь заалт нь дээрхи заалтуудын нэгэн адил төрийн тодорхой бодлогыг хэрэгжүүлэхэд, өөрөөр хэлбэл, төсвийн хөрөнгийг үр ашгийг зарцуулахаас урьдчилан сэргийлэх, өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь заалт нь аж ахуйн нэгжүүдийг ялгаварлаж шинээр байгуулагдсан, чадваргүй, шаардлага хангахгүй нь тодорхой аж ахуйн нэгжид илүү боломж олгох бодлогыг биш харин нийт ард иргэдийн ашиг, сонирхлын үүднээс төрийн үйл ажиллагааг зохих хэмжээнд явуулах, түүнд төсвөөс хуваарилсан мөнгөн хөрөнгийг үр ашгийг зарцуулах, эцсийн дүнд төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлэх бодлогыг баримталсан бөгөөд ингэхдээ нийт аж ахуйн нэгжүүдэд төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх ижил боломж олгосон гэж үзэж байна. Хуулийн төслийг хэлэлцэх явцад чадвар, туршлагатай цөөн аж ахуйн нэгжид нэг

төрийн бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хэд хэдэн гэрээг байгуулах нь ажил, үүргийг хугацаанд нь, чанартай биелүүлэх магадлал буурч, төсвийн хөрөнгийг үр ашгийг зарцуулах, эцсийн дүнд төрөөс иргэд, бусад этгээдэд үзүүлэх үйлчилгээ тасалдах сөрөг үр дагавартай болно.

Иргэн Б.Баярын өргөдөлд туссан санал нь хэт туйлширсан, өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгжүүд зөвхөн төрийн байгууллагад бараа, ажил, үйлчилгээ нийлүүлж түүнээс олсон ашгаар амьдрах, үгүй бол дампуурах юм шиг, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дээрхи заалт нь аж ахуйн нэгж болон иргэдийг өмч хөрөнгөөр нь ялгавартай хандсан, өмчлөгчийн эрхэд халдсан, Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэхэд саад болох, шинээр байгуулагдсан жижиг аж ахуйн нэгжүүд хуульд заасан шалгуурыг хангахгүйгээр тендерт оролцож болох мэтээр бичсэн байна. Ер нь цаашид том компаниуд хувь хүнээр дамжуулан төрийн бодлогыг эсэргүүцсэн, хуулийн бүх этгээд нэгэн адил дээдлэх зарчмыг зөрчсөн ийм үйл ажиллагаа явуулж байгаа буруу практикийг Үндсэн хуулийн цэц шийдвэртэйгээр таслан зогсоох нь зүйтэй гэж үзэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар бараа, ажил, үйлчилгээ худалдан авч байгаа этгээд тендер шалгаруулалтад оролцуулах аж ахуйн нэгжийг шалгаруулах нөхцөл, журмыг нарийвчлан тусгасан. Тухайлбал, Урьдчилсан сонголт явуулах /13 дугаар зүйл/, Ерөнхий нөхцөлийг магадлах /14 дүгээр зүйл/, Санхүүгийн чадавхийг үнэлэх /15 дугаар зүйл/, Техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх /16 дугаар зүйл/ гэх мэт. Мөн хуулийн зүйл, хэсэг, заалтад олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзсан, аж ахуйн нэгжийг ялгаварласан зүйл байхгүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт нь иргэн Б.Баярын өргөдөлд заасан Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 1, 2, 4, Аравдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 3/г, 4/, Далдугаар зүйлийн 1 дэх заалтын дурдсан хэсгийг зөрчсөн гэж үзэхгүй байна” гэжээ.



Үндэслэл:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр тухайн жилд зарлагдсан тендер шалгаруулалтад хуулийн этгээдээс 6-аас дээшгүй удаа оролцож болох бөгөөд үүнээс 3 удаад тендерт шалгарсан бол тухайн жилд дахин тендер шалгаруулалтад оролцохыг хориглоно" гэсэн хязгаарлалт нь төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд хийгдсэн гэж үзэх үндэстэй байна.

2. Хуулийн дээрх заалтаар тендер шалгаруулалтад оролцогчийг хөрөнгө чинээгээр ялгаварласан, өмчлөгчийн эрхэд халдсан, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр тухайн жилд зарлагдсан тендер шалгаруулалтад хуулийн этгээдээс 6-аас дээшгүй удаа оролцож болох бөгөөд үүнээс 3 удаад тендерт шалгарсан бол тухайн жилд дахин тендер шалгаруулалтад оролцохыг хориглоно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 1, 2, 4, Аравдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 3/, 4/, Далдугаар зүйлийн 1 дэх заалтыг холбогдох хэсгийг зөрчсөн гэснийг хүлээн авах боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн Хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон **ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

тухай" Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"; Тавдугаар зүйлийн 1-д заасан "Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна", 2-т заасан "Төр нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална", 4-т заасан "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна"; Аравдугаар зүйлийн 2-т заасан "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ"; Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", 2-т заасан "Хүнийг ...хөрөнгө чинээ, ...ялгаварлан гадуурхаж үл болно"; Арван зургадугаар зүйлийн 3/-т заасан "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй"; 4/-т заасан "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй"; Далдугаар зүйлийн 1-д заасан "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ **Н.ЖАНЦАН**

ГИШҮҮД **П.ОЧИРБАТ**

Ж.АМАРСАНАА

Ч.ДАШНЯМ

Д.НАРАНЧИМЭГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргаа.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265956
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 3